

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.8, 7.1.9 дахь заалт:**

“7.1.8. Улс төрөөс ангид байх;

7.1.9. Хөгжлийн банк энэ хуульд заасан үйл ажиллагаа явуулахад аливаа зөвшөөрөл шаардахгүй.”

#### **2/8 дугаар зүйлийн 8.5, 8.6 дахь хэсэг:**

“8.5. Хөгжлийн банкнаас энэ хуулийн 8.1.1, 8.1.3-т заасны дагуу олгох санхүүжилтийн дээд хэмжээ нь төслийн нийт өртгийн 85 хувиас хэтрэхгүй байна.

“8.6. Энэ хуулийн 8.1.9-д заасан үйл ажиллагаанаас бусад шийдвэрийг Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлага гаргах ба шийдвэр гаргахтай холбоотой журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.”

#### **3/8<sup>1</sup> дугаар зүйл:**

#### **“8<sup>1</sup> дугаар зүйл. Экспорт, импортын санхүүжилт олгох**

8<sup>1</sup>.1. Хөгжлийн банкны экспорт, импортын санхүүжилт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

8<sup>1</sup>.1.1. экспортын зээл;

8<sup>1</sup>.1.2. санхүүжилтийн шугам;

8<sup>1</sup>.1.3. дамжуулан зээл;

8<sup>1</sup>.1.4. аккредитив ;

8<sup>1</sup>.1.5. баталгаа ;

8<sup>1</sup>.1.6. бараа, үйлчилгээний төлбөр тооцоог шилжүүлэх, хүлээн авах;

8<sup>1</sup>.1.7. хуулиар хориглоогүй бусад төрлийн экспорт, импортын үйл ажиллагаанд хамаарах худалдааны санхүүжилт.

8<sup>1</sup>.2. Энэ хуулийн 8<sup>1</sup>.1-д заасан төрлийн санхүүжилтийг дараах зорилгоор олгоно. Үүнд:

8<sup>1</sup>.2.1. техник, технологи, түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортолж буй дотоодын хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх;

8<sup>1</sup>.2.2. дотоодын хуулийн этгээдээс техник, технологи, түүхий эд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч буй гадаад улсын хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх;

8<sup>1</sup>.2.3. дотоодын хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт шаардлагатай бараа, техник, тоног төхөөрөмжийг импортоор худалдан авахад дэмжлэг үзүүлэх.

8<sup>1</sup>.3.Хөгжлийн банкнаас экспорт, импортын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батална.

8<sup>1</sup>.4.Хөгжлийн банк нь энэ хуулийн 25.1-д заасан үзүүлэлт, журам, 28 дугаар зүйлд заасан хязгаарлалтад нийцүүлэн дангаар болон бусад этгээдтэй хамтран гуравдагч этгээдэд энэ хуулийн 8<sup>1</sup>.1.1-8<sup>1</sup>.1.3-д заасан үйлчилгээг үзүүлж болно.

8<sup>1</sup>.5.Экспорт, импортын санхүүжилт хийх төсөл, хөтөлбөр нь энэ хуулийн 10.1.3, 10.1.7-д заасан шаардлагыг хангасан байхыг шаардахгүй.”

#### **4/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.7 дахь заалт:**

“10.1.7.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, зураг төсөл, төсвийг төрийн эрх бүхий байгууллагаар батлуулсан байх;”

#### **5/10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг:**

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан хамтран санхүүжилт хийх журам, 10.5-д заасан шаардлагыг тогтоосон журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.”

#### **6/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:**

“13.3. Хөгжлийн банкны дотоодын зах зээлд арилжсан төгрөгийн үнэт цаас нь хөрвөх чадвар, эрсдэлийн үнэлгээний хувьд Монгол улсын засгийн газрын үнэт цаастай ижил байна.”

#### **7/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.14, 20.1.15 дахь заалт:**

“20.1.14.Хөгжлийн банкны авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг бодлогыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хянах.

20.1.15.Хөгжлийн банканд хийсэн хяналт, шалгалтын дагуу илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилтийг хувьцаа эзэмшигчид жил бүр тайлагнах.”

#### **8/20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг:**

“20.7.Төлөөлөн удирдах зөвлөл нь Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлыг дор дурдсан тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ:

20.7.1.хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон;

20.7.2.биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг өөрөө гаргасан;  
20.7.3.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон.”

**9/ 21 дүгээр зүйлийн 21.7, 21.8, 21.9 дахь хэсэг:**

“21.7.Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлыг 5 жилийн хугацаатай томилох бөгөөд 1 удаа улируулан томилж болно.

21.8.Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг хууль тогтоомжийн хүрээнд сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

21.9.Гүйцэтгэх удирдлага багийн үйл ажиллагааны журмыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

**10/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн 23.1.9 дэх заалт:**

“23.1.9. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн дүгнэлт, тайланг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх;”

**11/30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг:**

“30.4.Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, гүйцэтгэлийн явц, судлагдаж буй төслийн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлнэ.”

**12/31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг:**

“31.2.Энэ хуулийн 21<sup>1</sup>.1-ийг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.3.Энэ хуулийн 31<sup>1</sup>.2, 31<sup>1</sup>.3-ийг зөрчсөн этгээд төрийн албан хаагч бол энэ үйлдэл нь түүнийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.

31.4.Энэ хуулийн 31.3-д заасан этгээд нь аливаа хууль бус үйлдлийг бусдаар хийлгэсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

**13/31<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“31<sup>1</sup> дүгээр зүйл.Хориглох үйл ажиллагаа**

31<sup>1</sup>.1.Хөгжлийн Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, хянан шалгагч, ажилтанд хориглоно.

31<sup>1</sup>.2.Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь

Гүйцэтгэх удирдлагын багтай Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцохоос бусад байдлаар уулзахдаа аливаа үүрэг даалгавар өгөх, харилцаа холбооны бусад хэрэгслээр дамжуулан харилцах, мөн Хөгжлийн банкны ажилтан, албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх удирдлагад аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

31<sup>1.3</sup>.Аливаа этгээд Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтан, хянан шалгагч, ажилтныг ажил, албан үүрэгтэй нь холбогдуулан хууль, дүрэм, журам зөрчсөн шийдвэр гаргах, үйлдэл, эс үйлдэхүй хийхийг хүсэх, шаардах, албадах, сүрдүүлэх, заналхийлэхийг хориглоно.

31<sup>1.4</sup>.Энэ хуулийн 10.5-д заасан журамд жилд нэгээс дээш удаа нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

31<sup>1.5</sup>.Энэ хуулийн 31<sup>1.2</sup>, 31<sup>1.3</sup>-д заасан үйлдлийг баримтжуулах, дуу, дүрсний бичлэг хийхэд аливаа этгээдээс зөвшөөрөл авах, урьдчилан мэдэгдсэн байхыг шаардахгүй.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд дараах агуулгатай Дөрөвдүгээр бүлгийг нэмсүгэй.

**1/ Дөрөвдүгээр бүлэг:**

**“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН  
БАНКНЫ САНХҮҮЖИЛТ АВСАН  
ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГА**

**21<sup>1</sup> дүгээр зүйл.**Хөгжлийн банкнаас санхүүжилт, баталгаа батлан даалт авсан этгээдийн хариуцлага

21<sup>1.1</sup>.Хөгжлийн банкнаас авсан санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.

21<sup>1.2</sup>.Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээд нь байгууллагын үйл ажиллагааны тайлан, зардлын тайлан, Хөгжлийн банкнаас олгосон санхүүжилтийн зарцуулалтын тайлан, байгууллагын дансны хуулганы мэдээллийг гэрээгээр тохиролцсон хугацаанд, хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажсан тайланг жил бүр тус тус Хөгжлийн банканд хүргүүлнэ.

21<sup>1.3</sup>. Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээд нь энэ хуулийн 21<sup>1.2</sup>-д заасан мэдээлэл болон Хөгжлийн банкны барьцаанд буй хөрөнгийн талаарх мэдээлэл, байршил, бүрэн бүтэн байдал, эзэмшил, ашиглалттай холбоотой мэдээллийг шаардсан тухай бүр Хөгжлийн банканд гаргаж өгнө.

21<sup>1.4</sup>.Санхүүжилт, баталгаа батлан даалт авсан этгээдийн эзэмшил, өмчлөл, хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орсон, орохоор удирдлагын шийдвэр гарсан тухай бүр Хөгжлийн банканд мэдээлнэ.

21<sup>1.5</sup>.Хөгжлийн банкны барьцаанд байгаа хөрөнгө, түүнтэй холбоотой гуравдагч этгээдийн шаардах эрх үүссэн, иргэний шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх ажиллагаа, дампуурлын ажиллагаа үүссэн, зээлийн мэдээллийн санд зээлийн ангилал буурсан тухай бүр Хөгжлийн банканд мэдээлнэ.

21<sup>1.6</sup>.Энэ зүйлийн 21<sup>1.2</sup>-21<sup>1.5</sup>-г зөрчсөн, мэдээ баримтыг хуурамчаар үйлдсэн, худал мэдүүлсэн нь санхүүжилтийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан үндэслэл болно.

21<sup>1.7</sup>.Хөгжлийн банкны барьцаанд байгаа хөрөнгийн бүрэн бүтэн байдал ашиглалтыг шалгахаар Хөгжлийн банкнаас шаардсан тохиолдолд уг объектод төлөөллийг саадгүй нэвтрүүлэх боломжоор хангана.

### **21<sup>2</sup> дүгээр зүйл.Хөгжлийн банкнаас авсан санхүүжилтийг хугацаандаа эргэн төлөөгүйн хариуцлага**

21<sup>2.1</sup>.Хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний хугацаа дууссан нь тухайн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй этгээдийг гэрээний хугацаа дууссанаас хойших гэрээнд заасан үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүү төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

21<sup>2.2</sup>.Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан этгээд нь санхүүжилтийг гэрээнд заасны дагуу төлөөгүй, зориулалтын дагуу ашиглаагүй эсхүл хууль, гэрээнд заасан үндэслэлээр Хөгжлийн банкны санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалсан бол гэрээ цуцлагдсан өдрөөс хойш санхүүжилтийг бүрэн эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд төлөгдөөгүй үлдсэн үндсэн санхүүжилт болон түүнээс Төв банкны бодлогын хүү дээр 8 хувийн хүүг нэмсэн хувиар тооцсон нэхэмжлэлийн шаардлагын хүүг төлнө.”

**3 дугаар зүйл.**Хөгжлийн банкны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

“5.1.Хөгжлийн банк нь экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд шинээр нэвтрүүлэн төрөлжүүлэх, үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, ногоон эдийн засгийг дэмжих зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд буюу төрөлжсөн банк байна.”

#### **2/8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг:**

“8.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

8.1.1.экспорт, импортын санхүүжилт олгох;

8.1.2.зээл авах, гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах;

8.1.3.эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

8.1.4.төлбөр тооцоо хийх;

8.1.5. баталгаа, батлан даалт гаргах;  
8.1.6. үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах;  
8.1.7. валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;  
8.1.8. төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх;  
8.1.9. компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх;  
8.1.10. төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх;  
8.1.11. тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, нэвтрүүлэх.  
8.2. Энэ хуулийн 8.1.1-т заасан үйл ажиллагаанд Хөгжлийн банкны нийт санхүүжилтийн дүнгийн 50-иас доошгүй хувийг зарцуулна.”

### **3/9 дүгээр зүйл:**

#### **“9 дүгээр зүйл. Зээл авах, гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах**

9.1. Хөгжлийн банк нь хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бизнес төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөөний дагуу, нэг удаагийн болон үе шаттай санхүүжилт авч болно.”

### **4/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.3 дахь заалт:**

“10.1.3. техник, эдийн засгийн үндэслэлтэй байх;”

### **5/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.5, 10.1.6 дахь заалт:**

“10.1.5. төслийн эрсдэлийн үнэлгээ, санхүүжилт авах үндэслэл, эдийн засаг, нийгмийн үр нөлөөг мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;”

### **6/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:**

10.2. Хөгжлийн банк энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хангасан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх төсөл, хөтөлбөрийг гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлж болно.

### **7/10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэг:**

“10.3. Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан шаардлага хангагдаж байгаа эсэхийг Хөгжлийн банкны гүйцэтгэх удирдлага тогтооно.

10.4.Энэ хуулийн 10.3-д зааснаас бусад нөхцөл, шаардлагыг холбогдох хууль тогтоомжоор тодорхойлно.”

**8/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:**

“11.1.Хөгжлийн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу зохицуулна.”

**9/13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:**

“13.1.Хөгжлийн банк нь хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бизнес төлөвлөгөөнд нийцүүлэн үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулж болно.”

**10/14 дүгээр зүйл:**

**“14 дүгээр зүйл.Валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах**

14.1.Хөгжлийн банкны валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.”

**11/19 дүгээр зүйлийн 19.5.4 дэх заалт:**

“19.5.4.төрийн улс төрийн албан тушаал хашдаггүй байх, сүүлийн 5 жил төрийн улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;”

**11/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.1 дэх заалт:**

“20.1.1.Хөгжлийн банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн батлах;”

**12/20 дугаар зүйлийн 20.1.6 дахь хэсэг:**

“20.1.6.Хөгжлийн банкны санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, хөрөнгийн удирдлагын бодлогыг батлах;”

**13/21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсэг:**

“21.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан бүтэц, орон тооны хүрээнд Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний бүтэц, орон тоог Гүйцэтгэх захирал тогтоох ба түүнийг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал даргална.

21.3.Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлыг энэ хуулийн 20.1.4-т заасан журмын дагуу олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, чөлөөлнө.”

**14/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн 21.5.3 дахь заалт:**

21.5.3.Хөгжлийн банкны жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах, гүйцэтгэлийг тайлагнах;

**15/21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсгийн 21.6.9 дэх заалт:**

“21.6.9. хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, эх үүсвэрийн чөлөөт үлдэгдлийг Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаасанд байршуулах, эсхүл харилцан мөнгө байршуулсан тохиолдолд арилжааны банкны үнэт цаасанд байршуулан үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;”

**16/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:**

“31.1. Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.”

**4 дугаар зүйл.**Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1.6 дахь заалтын “баталгаа” гэснийг “баталгаа, батлан даалт” гэж, 20.3 дахь хэсгийн “сард” гэснийг “улиралд” гэж, 21.4 дахь хэсгийн “Гүйцэтгэх захирал” гэснийг “Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд” гэж, 21.5.5 дахь заалтын “Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон” гэснийг “Хууль, дүрэм, гэрээгээр олгосон” гэж, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн “дөрөвдүгээр бүлэг” гэснийг “тавдугаар бүлэг”, “тавдугаар бүлэг” гэснийг “зургаадугаар бүлэг”, “зургаадугаар бүлэг” гэснийг “долдугаар бүлэг”, “долдугаар бүлэг” гэснийг “наймдугаар бүлэг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 17 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.2, 31.1.3, 31.1.4, 31.1.5, 31.1.6 дахь заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Хүчин төгөлдөр болох.Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ